



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**УВС АЙМГИЙН ОЙРАД ХӨГЖИМТ ЖҮЖГИЙН ТЕАТРТ ИРГЭНИЙ ИРҮҮЛСЭН
ХҮСЭЛТИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

ХШҮДАГ/2025/ХШ-02

УЛААНБААТАР ХОТ

2025 он

УВС АЙМГИЙН ОЙРАД ХӨГЖИМТ ЖҮЖГИЙН ТЕАТРТ ИРГЭНИЙ ГАРГАСАН ХҮСЭЛТИЙН ДАГУУ ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс тус байгууллагын удирдлага, холбогдох албан хаагчдад цахимаар хяналт шалгалтыг удирдамжийг танилцуулан, шаардлагатай баримтыг цахим хэлбэрээр хүлээн авч, иргэн Ж.Оюунчимэгийн 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдөр ирүүлсэн хүсэлтэд дурдагдсан асуудлаар дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор шалгалтыг гүйцэтгэлээ.

Ажлын хэсэгт Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Түмэндэмбэрэл, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, дотоод аудитор Г.Шүрэндолгор, гэрээт ажилтан О.Пүрэвсүх нар ажиллалаа.

Батлагдсан удирдамжийн дагуу Увс аймгийн Ойрад хөгжимт жүжгийн театрт Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Зардал баталж, эрх шилжүүлэх” тухай А/50 дугаар тушаалын дагуу олгосон 150.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс олгосон 100.0 сая төгрөгөөр бүтээсэн “Тэнгэрийн Сэнтий” жүжгийн уран бүтээлд зарцуулсан төсвийн зарцуулалтад дараах асуудлаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Уран бүтээлд зарцуулсан төсвийн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдлийг шалгах;
- Уран бүтээлийн тоглолтод зориулж бүтээсэн хувцас, хэрэглэлийг байгууллагын өмч хөрөнгөд бүртгэсэн байдлыг шалгах;
- Улаанбаатар хотод тоглолт хийхэд жүжигчин, уран бүтээлчид олгосон албан томилолтын зардлын зарцуулалт, анхан шатны баримтын бүрдлийг шалгах;
- Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан А.Баярмагнай ажлаас чөлөөлөгдсөний дараа тушаал гаргах, гэрээ батлах, төсвийн зарцуулалтын гүйлгээ хийхэд гарын үсэг зурсан эсэх асуудлыг шалгах;

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ТОГТООГДСОН БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Гомдолд “Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Зардал баталж, эрх шилжүүлэх” тухай А/50 дугаар тушаалын дагуу олгосон 150.0 сая төгрөг, аймгийн Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн А/109 дүгээр захирамжаар олгосон 100.0 сая төгрөг нийт 250.0 сая төгрөгөөр бүтээсэн “Тэнгэрийн Сэнтий” бүжгэн жүжгийн уран бүтээлийн санхүүжилт зориулалт бусаар зарцуулагдсан, уран бүтээлийн хувцас хэрэглэл, тайз декрац гэх зүйл үлдээгүй” гэх асуудлыг шалгахад дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/14 дүгээр “Тэнгэрийн сэнтий дуулалт бүжгэн жүжиг туурвих тухай” тушаал батлагдсан байна. Тус тушаалын 1 дүгээр хавсралтаар Уран бүтээл худалдан авах 91.0 сая төгрөг, уран бүтээл бүтээл туурвихтай холбоотой зардал 149.9 сая төгрөг, Маркетингийн зардал 9.1 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төсөвлөгдсөн байна.

1.1. Уран бүтээл худалдан авах зардлын зарцуулалтын тухай

Уран бүтээл худалдан авах зардалд 91.0 сая төгрөгөөр төсөвлөж, гүйцэтгэлээр 92.8 сая төгрөгийг 5 иргэнд олгож, 1.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь **Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”** гэсэн заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт 1 /сая төгрөгөөр/

№	Зардлын утга	Тоо хэмжээ	Баталсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү /илүү/	Гүйцэтгэгч
Уран бүтээл худалдан авах зардал						
1	Ерөнхий найруулагч	1	19.0	19.9	(0,9)	Д.Энхбаяр
2	Зохиол	1	15.0	15.0	-	На.Сүхбаатар
3	Хөгжмийн зохиолч	1	19.0	19.0	-	Б.Эрдэнэбат
4	Бүжиг дэглээч	1	19.0	19.9	(0,9)	М.Мөнгөнцэцэг
5	Хувцасны зураач, тайзны зураач, мастер	1	19.0	19.0	-	Н.Энхбаяр
Нийт дүн			91.0	92.8	(1.8)	

Жүжгийн зохиолыг МУБИС-ийн түүхийн тэнхимийн профессор, түүхийн ухааны доктор На.Сүхбаатараас 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дугаартай хамтран ажиллах 15.0 сая төгрөгийн гэрээг байгуулан ажилласан ба гэрээний 7.2-т заасны дагуу 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр жүжгийн зохиолыг хүлээлгэн өгөхөөр тохиролцсон байна. Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар жүжгийг хүлээн авах Комиссыг томилсон боловч энэ Комисс ажилласан талаарх баримт байхгүй, жүжгийн зохиолыг театрын Уран сайхны зөвлөл хүлээн авсан тухай хурлын тэмдэглэл үйлдээгүй, оюуны өмчийн бүртгэлд бүртгээгүй, зохиолыг хөрөнгийн дансанд тусгалгүй шууд зарлагаар бүртгэсэн мөн гэрээгээ дүгнээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Жүжгийн ерөнхий найруулагчаар Д.Энхбаяр, бүжиг дэглээчээр М.Мөнгөнцэцэг нартай тус бүр 19.9 сая төгрөг, хувцасны зураач, тайзны зураач, мастераар Н.Энхбаяртай 19.0 сая төгрөг, хөгжмийн зохиолчоор Б.Эрдэнэбаттай 19.0 сая төгрөгөөр тус тус хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Эдгээр уран бүтээлчидтэй ажил үйлчилгээ дууссаны дараа гэрээг дүгнээгүй атал санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Мөн жүжгийн ерөнхий найруулагч, бүжиг дэглээчтэй хамтран ажиллах гэрээ байгуулахдаа батлагдсан төсвөөс тус тус 0,9 сая төгрөг буюу нийт 1.8 сая төгрөгийн илүү зардал олгохоор гэрээ байгуулж олгосон байна.

1.2. Уран бүтээл туурвихтай холбоотой зардлын тухай

Тус зардалд нийт 7 төрлийн ажил үйлчилгээг 149.9 сая төгрөгийг зарцуулахаар төсөв баталж, гүйцэтгэлээр 139.8 сая төгрөгийг 9 иргэн, 2 компанид гэрээ байгуулан олгосон байна.

Хүснэгт 2 /сая төгрөгөөр/

№	Зардлын утга		Тоо хэмжээ / ширхэгийн үнэ	Баталсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү /дутуу/	Гүйцэтгэгч иргэн, хуулийн этгээдийн нэр
1	Тайзны макет, тайзны зураг		1	17.0	17.0	-	М.Мөнхбаяр
2	Тайз хэрэглэл чимэглэл			18.0	18.0	-	Д.Батнасан
3	Бүжигчин, жүжигчин, Хөгжимчдийн хувцас, эдлэл, хэрэглэл, оёдол			66.3	60.6	5.7	Г.Ганчимэг, Б.Явуулбилэг, Б.Содбилэг, Натурдаанс ХХК
4	Гутал хийх зардал	Ард гутал /хос/	39*350.0	13.6	13.5	0,1	Б.Жамбалсанжид
		Бүжгийн гутал /хос/	16*250.0	4.0	4.0	-	Натурдаанс ХХК,
5	Хөгжмийн мастер бичлэг хийлгэх			10.0	10.0	-	Ц.Отгонзул мастринг нь хийгдээгүй
6	Дуу бичүүлэх, дууны мастринг хийлгэх			9.0	9.0	-	
7	Камер, утааны аппарат, проектор			12.0	7.7	4.3	Цэнгэлмаа-Хонин хуучир, Эгшиглэн магнай ХХК-Эвэр бүрээ, Баярсүрэн-Морин хуур
Нийт дүн				149.9	139.8	10.1	

Бүжигчин, жүжигчин, хөгжимчдийн хувцас, эдлэл хэрэглэл, оёдолын 66.0 сая төгрөгийн төсөвтэй зардлыг 3 хувь хүн, 1 хуулийн этгээдээр хийлгэхээр гэрээлсэн байна. Иргэн Г.Ганчимэгтэй 15.0 сая төгрөгний хөгжимчдийн хувцас нийлүүлэхээр, иргэн Б.Явуулбилэгтэй 15.2 сая төгрөгний хувцас нийлүүлэхээр, Б.Содбилэгтэй 10.4 сая төгрөгийн малгай нийлүүлэхээр хамтран ажиллах гэрээ байгуулжээ. Эдгээр иргэд нэг гэр бүлийн гишүүд байна. Гэрээг дүгнээгүй санхүүжилтийг бүрэн олгосон.

“Натур даанс” ХХК-тай 19.8 сая төгрөгний 32 ком хувцас хийлгэхээр гэрээлсэн ба гэрээнд тус компанийн захирал гэж тус жүжгийн ерөнхий найруулагчаар ажиллаж байгаа Д.Энхбаяр гарын үсэг зурсан байна. Тус компаний мэдээллийг нээлттэй мэдээллийн сангаас шалгахад, тус компаний захирлаар жүжгийн ерөнхий найруулагчаар ажиллаж байгаа Д.Энхбаярын эхнэр бөгөөд тус жүжгийн бүжиг дэглээчээр ажиллаж байгаа М.Мөнгөнцэцэг бүртгэлтэй байна. “Натур даанс” ХХК-ний улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэн үндсэн үйл ажиллагааны төрөлд “хувцас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа” байхгүй байна.

“Натур даанс” ХХК-тай 32 ком хувцас хийлгэхээр байгуулсан гэрээг дүгнэсэн актыг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр дүгнэжээ. Тус актын ажлын нэрийг гэрээнд “32 ком хувцас хийлгэх”-ээр заасан нэршлээр бичих байтал “Түүхийн ухааны доктор На.Сүхбаатарын цомнол Жиргант Зүүнгар” зохиолоос сэдэвлэн “Тэнгэрийн сэнтий” үндэсний дуулалт бүжгэн жүжгийг продюсерлэж тайзнаа тоглуулах” гэж зөрүүтэй бичжээ. Актад 6 төрлийн үйл ажиллагаа хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн гэжээ. Гэтэл эдгээр 6 төрлийн ажил үйлчилгээний 5 нь гэрээнд заагдаагүй ажил үйлчилгээ байна.

Дээрх төсөвлөсөн зардал нь Төрийн болон орон нутгийн өмчит бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны тухай /цаашид ТБОНӨХБАҮХАТ гэх/ хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу “Харьцуулалтын арга”-аар худалдан авах байтал шууд гэрээлж ажлыг гүйцэтгэсэн нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимыг баримтлана”, 10.3-т *“Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”*, Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Жүжгийн гутал хийх зардлыг иргэн Б.Жамбалсанжидтай 10.5 сая төгрөгийн гэрээ байгуулж нэмэлт өөрчлөлтөөр 3.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн санхүүжилтийг олгосон байна. Гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй санхүүжилтийг бүрэн олгосон.

Хөгжмийн мастер бичлэг хийлгэх, Дуу бичүүлэх дууны мастеринг хийлгэх хоёр зардлыг иргэн Ц.Отгонзултай нийт 19.0 сая төгрөгөөр хийлгэхээр гэрээ байгуулсан байна. Энэ ажлын санхүүгийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газраас шалгаж, дараах зөрчлийг илрүүлэн зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

“...Ойрад хөгжимт жүжгийн театр нь Соёлын сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/50 дугаар тушаалаар 150.0 сая, аймгийн Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар 100.0 сая, нийт 250.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Тэнгэр сэнти” дуулалт бүжгэн жүжгийг туурвисан байна. Уг жүжгийг хүлээн авах комиссыг Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/26 тушаалаар томиловч боловч хүлээн авах комисс ажилаагүй байхад санхүүжилтийг бүрэн өгсөн, дээрх ажлын хүрээнд **хөгжмийн мастер бичлэг хийгээгүй, дуу бичүүлээгүй, дууны мастерниг хийлгээгүй, бүжигчид, дуучид, жүжигчид, хөгжимчдийн хувцас, хэрэгсэл шаардлага хангахгүй, дутуу ирсэн** зэрэг асуудал нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь заалтад “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулсан 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн №02 дугаартай Тэнгэрийн сэнтий дуулалт жүжгийн хөгжмийн найруулга, микс, мастерингаар ажиллах гэрээний 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “... үлдэгдэл эцсийн тооцоог... 30

хувь болох 5.7 сая төгрөгийг 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн дотор хүлээлгэн өгч тооцоог дуусгана” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна” гэжээ.

Камер, утааны аппарат, проектор авахаар төсөвлөгдсөн байсан зардлаар Хонин хуучир, Эвэр бүрээ, Морин хуур нийт 7.7 сая төгрөгийн 3 хөгжмийн хэрэгсэлийг тушаалд өөрчлөлт оруулалгүйгээр худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Захиалгаар хийлгэсэн жүжгийн хувцас, гутал, малгай дагалдах жижиг хэрэгслийг санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөөр бүртгэх байтал “Бараа материалын тайлан”-гийн бусад хангамжийн материалын дансанд бүртгэж тайлагнасан байна. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь хувцас хэрэглэл хүлээн авсан тухай хурлын тэмдэглэл үйлдээгүй, хувцас, хэрэгслийг 2024 оны 7-9 дүгээр сарын хооронд хүлээн авсан атал 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүлээж авснаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “Үнэн зөв байх”; 5.1.5 дэх заалт “Хэмжигдэхүйц байх”, 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасан заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

1.3 Маркетингийн зардлын тухай

Уран бүтээлийн маркетингийн зардлыг 9.1 сая төгрөгөөр төсөвлөж, гүйцэтгэлээр 25.5 сая төгрөгийг 1 иргэн, 1 хуулийн этгээдэд олгож, 16.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь **Төсвийн тухай хуулийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”** гэсэн заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт 3 /сая төгрөгөөр/

№	Зардлын утга	Тоо хэмжээ	Баталсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү /илүү/	Гүйцэтгэгч
Маркетингийн зардал						
1	Концертны ТВ, рекламны шторк хийх, Хэвлэлийн зардал	1	5.5	10.5	(5.0)	С.Энхтайван
2	Хэвлэлийн зардал	1	3.6	15.0	(11.4)	Пропикс ХХК
8	Нийт дүн		9.1	25.5	16.4	

Жүжгийн маркетингийн зардалд 9.1 сая төгрөг төсөвлөгдсөн боловч Пропикс ХХК-тай 15.0 сая төгрөгийн хөрөг нэвтрүүлэг, шторк хийх гэрээ байгуулж, гэрээг дүгнэлгүй санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Жүжгийг Улаанбаатар хотноо тоглохтой холбоотой тоглолтын маркетинг хийх болон 2200 ширхэг билет, 200 ширхэг урилга зарж борлуулах, зар сурталчилгаа хийлгэхээр 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 01 дугаартай хамтран ажиллах гэрээг 15.0 сая төгрөгөөр С.Энхтайвантай байгуулсан байна. Гэрээний дагуу

урьдчилгаа төлбөрт 10.5 сая төгрөгийг шилжүүлсэн ба гэрээний үлдэгдэл тооцоо 4.5 сая төгрөгийг санхүүгийн тайлангийн өглөгийн дансанд бүртгэж тайлагнаагүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар С.Энхтайвантай тоглолтын билетийн тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, жүжгийн орлого болох 20.2 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Дээрх үйлдэл нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Хоёр. Гомдолд “Улаанбаатар хотод тоглолт хийхэд жүжигчин, уран бүтээлчид олгосон албан томилолтын зардлын зарцуулалт, анхан шатны баримтын бүрдлийг шалгах” гэснийг шалгахад дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

Улаанбаатар хотод 2024 оны 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд тоглогдох “Тэнгэрийн сэнтий” бүжгэн жүжигт уран бүтээлч, ажлын албаны нийт 65 уран бүтээлчдийн албан томилолтын зардлыг баталсан тушаал, шийдвэргүй байна. Албан томилолтын зардалд буудлын 4.5 сая, хоолны 16.0 сая төгрөгийг зарцуулсан.

Тус театрын 57 уран бүтээлчдийг Улаанбаатар хотод “Мазаалай трейд ХХК”-ийн Хавана зочид буудалд 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 29-ний өдрийг хүртэл нийт 4.5 сая төгрөгөөр гэрээ байгуулж, байрлуулсан. Эдгээр уран бүтээлчдийн хоолны зардалд өдрийн 50.0 мянган төгрөгөөр тооцож 4 өдрийн 200.0 мянган төгрөг буюу нийт 12.6 сая төгрөгийг олгосон нь Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/52 тоот тушаал, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-тай нийцэж байна.

Зочид буудлаас гадуур байрласан (хүснэгт 4-т дурдсан) 6 ажилтанд 1 өдрийн 50.0 мянган төгрөгөөр бодож 4 өдрийн 200.0 мянган төгрөг олгосон, нягтлан бодогч Х.Өнөрдулам өөртөө албан томилолтын зардал буудал, хоолны зардалд 1 өдрийн 200.0 мянган төгрөгөөр тооцож 5 өдрийн 1 сая төгрөгийг олгосон. Энэ нь гадуур байрласан 6 албан хаагчдад ялгавартайгаар хандсан гэж үзэхээр байна.

Хүснэгт 4 /мянган төгрөгөөр/

№	Албан хаагчдын нэрс	Албан тушаал	Томилолтын хоног	Томилолт	Нийт дүн
1	Х.Өнөрдулам	Нягтлан бодогч	5	200.0	1,000.0
2	Ц.Алтангэрэл	Цаг бүртгэгч	4	50.0	200.0
3	Н.Сийлэгмаа	Бичиг хэрэг-архив	4	50.0	200.0
4	Ж.Оюунчимэг	Зохион байгуулагч	4	50.0	200.0
5	А.Сайнсанаа	Фондын эрхлэгч	4	50.0	200.0
6	Ж.Алтанцэцэг	Билет шалгагч-үйлчлэгч	4	50.0	200.0
7	Ц.Янжиндулам	Билет шалгагч-үйлчлэгч	4	50.0	200.0
8	Нийт дүн				2,200.0

Гурав. Гомдолд “Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Баярмагнай ажлаас чөлөөлөгдсөний дараа тушаал гаргаж, гэрээ батлан,

төсвийн зарцуулалтын гүйлгээ хийсэн” гэх асуудлыг шалгахад дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/24 дугаар тушаалаар Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Баярмагнайг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн байна. Баярмагнай ар гэрийн гачигдалтай байсан тул албан үүрэгт ажлаа 2025 оны 12 дугаар сарын 02-ний өдөр хүлээлгэн өгсөн байна.

Тус театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр найруулагч Б.Батсүхийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр томилсон боловч төрийн сангийн гүйлгээний эрх баталгаажуулж, өмнөх даргын албан үүргээ гүйцэтгэж байх үеийн тушаалаар баталгаажсан гүйлгээг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр А.Баярмагнай дарга нь цахим тоон гарын үсгээр 25 удаагийн 122.7 сая төгрөгийн гүйлгээг баталгаажуулсан байна. Аймгийн Засаг даргын захирамж гарснаас хойш нэмж тушаал шийдвэр, гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

ДҮГНЭЛТ

“Тэнгэрийн сэнтий дуулалт бүжгэн жүжиг” туурвисан нь Увс аймгийн 100 жил, тус театр үүсгэн байгуулагдсан 60 жилийн ойг угтсан томоохон ажил болсон байна. Жүжгийг туурвихад шаардлагатай төсөв хөрөнгийг улс, орон нутгийн төсвөөр шийдүүлэн, нутгийн зон олон болон Улаанбаатар хотын үзэгчдийн хүртээл болгосон нь Баруун монгол түмний хэл соёл, урлагыг өвлүүлэн үлдээх, түгээхэд чухал ач холбогдолтой бүтээл болжээ.

Ажлын хэсгээс удирдамжид заасны дагуу гомдол гаргагчийн хөндсөн асуудалд дүн шинжилгээ хийн, орон нутгийн болон дээд шатны төсвийн захирагчаас олгосон төсвийн санхүүжилтийн зарцуулалт, үйл ажиллагааны орлогын зарцуулалт, түүний үр дүн, ашиглалтын талаар хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Уран бүтээлийн удирдлагын багийн ажлын хөлс болон маркетингийн зардалд 6 иргэн, 1 хуулийн этгээдэд 18.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
2. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгасан;
3. Зардлын тушаалаар баталсан төсөвт тусаагүй 7.7 сая төгрөгийн 3 хөгжмийн хэрэгслэлийг худалдан авсан;
4. Бүжигчин, жүжигчин, хөгжимчдийн хувцас, эдлэл хэрэглэл бэлтгэх болон оёдлын 66.0 сая төгрөгийн зардлыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлд заасан “Харьцуулалтын арга”-аар худалдан авах атал шууд гэрээ байгуулан худалдан авсан нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлана.”, 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй;
5. Жүжгийн маркетингийн зардалтай холбоотой 4.5 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй, 20.2 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн.

6. Байгууллагын холбогдох албан тушаалтнууд нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, ТБОНӨХБАҮХАТ хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүй ба байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналт сул байна. Иймд байгууллагын удирдлага болон захиргааны зүгээс санхүүгийн сахилга батыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэж байна.

Цаашид авч хэрэгжүүлэх дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтын дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл, эд хариуцагч нар жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулан эд хөрөнгийн тооллого хийн, нягтлан бодогчтой тооцоо нийлж, акт үйлдэн баталгаажуулан, санхүүгийн анхан шатны баримтыг хууль журмын хүрээнд иж бүрэн бүрдүүлж хэвших;
2. Иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний биелэлтэд тухай бүр хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд багтаан ажил үйлчилгээг хүлээн авах, гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээг тухай бүр дүгнэж, акт үйлдэн баталгаажуулсны дараа төлбөр тооцоог хийх;
3. “Тэнгэрийн сэнтий” дуулалт бүжгэн жүжгийг оюуны өмчтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж, холбогдох данс бүртгэлд тусгах;
4. Хөрөнгө худалдан авах, гэрээт ажил гүйцэтгүүлэхдээ, ТБОНӨХБАҮХАТ хууль, журмыг мөрдөж ажиллах;
5. Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг баримтлан өр, авлага үүсгэхгүй байх, өглөг авлага гарсан тухай бүр бүртгэх, тооцоо нийлсэн актаар баримтжуулж, данс бүртгэлд тусгах;
6. Албан томилолтын зардлыг тушаалаар баталгаажуулан олгох, томилолтоор ажиллах ажлын удирдамжид ажилтан, албан хаагчдын хийж гүйцэтгэх ажлыг нарийвчлан тусгаж, зайлшгүй шаардлагатай албан хаагчдад томилолтыг олгох, томилолтын зардлын санхүүгийн анхан шатны баримтын иж бүрдлийг хангах;
7. Дотоод хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн хариуг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор яамны ХШҮДАГ-т ирүүлэх.

СОЁЛ, СПОРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---oOo---